

## МОНГОЛЫН ХӨДӨӨГИЙН НИЙГМИЙН АСУУДЛААР БНСУ-ЫН ЭРДЭМТНИЙ ТУУРВИСАН СУДАЛГААНЫ ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Ц. Баатар

Сүүлийн үед Япон, Хятад, БНСУ, АНУ зэрэг Зүүн хойт Азийн оронд Монголын хөдөө аж ахуйг сонирхон судлах болж, энэ чиглэлээр явуулж буй шинжилгээний ажил ч нэлээд өргөжиж, судлаачдын тоо ч нэмэгдэж ирлээ. Тэдний нэг нь монголчуудын хэзээний танил болсон БНСУ-ын Данкугийн их сургуулийн Орон нутгийн хөгжлийн хүрээлэнгийн захирал, профессор Ким Юхйөг юм. Профессор Ким Юхйөг манай оронд ажлын айлчлалаар хэд хэдэн удаа ирж, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, хөдөө орон нутгаар явж, монголын түүх, эдийн засаг, нийгэм, соёлын талаар өргөн мэдлэгтэй болж, энэ чиглэлээр 30 орчим өгүүлэл бичиж БНСУ-д Монгол орныг сурталчлах талаар их зүйл санаачлан хийж буй солонгос анд нөхдийн маань нэг билээ.

Хөдөөгийн нийгмийн хөгжлийн асуудлаар судалгаа хийдэг энэ эрдэмтэнд монголын хөдөө онцгой сэтгэгдэл төрүүлсэн учир бие даасан судалгаа хийхээр сэтгэл шулуудаж богино хугацаанд нөр их зүтгэл гарган хөдөлмөрлөж «Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр загварт хот» гэсэн 350 хуудас бүхий томоохон бүтээл туурвиж 1991 оны долдугаар сард монгол хэлээр Сеулд хэвлүүлжээ.

Өмнөд Солонгос, Монголын хөдөөгийн нийгмийн хөгжлийг харьцуулан судалсан энэ бүтээл үндсэн 3 бүлгээс бүрдэл болж байна. «Шинэ тосгон хөдөлгөөн түүнийг хэрэгжүүлэх үзэл санаа» гэсэн тэргүүн бүлэг нь 5 анги, 14 зүйлтэй. Энэ бүлэгт зохиогч шинэ тосгон хөдөлгөөн нь БНСУ-ын хувьд нийгмийн хөгжлийг хангах нөөц хүч гэсэн утга агуулгатай болохыг тэмдэглээд Солонгос улсын бүтээн байгуулалтанд шинэ үеийг нээсэн түүхэн ач холбогдолтой шинэ тосгон хөдөлгөөн ямар нөхцөл байдлын дунд хэрхэн үүссэн тухай тодорхой өгүүлжээ.

1960 он хүртэл Солонгос орон, өмнөд солонгосын ард түмэн үймээн самуун, дайн дажин, ядуурал зүдрэлийн хүнд бэрхиг нуруундаа үүрч гараад 60-аад оноос өөрийн хүчинд тулгуурлан улс орныхоо хүчин чадлыг өвч дайчлан асар их хүнд бэрхшээл саадыг даван туулж, дорно дахинд хуруу дарамд орох төмөрлөгийн үйлдвэрийн иж бүрэн цогцолборыг амжилттай барьж ашиглалтанд оруулжээ. Энэ нь солонгосчуудад «хийвэл бүтдэг юм байна» гэсэн итгэл үнэмшлийг хүчтэй төрүүлж, сэтгэлийнх нь очийг бадраасан томоохон үйл явдал болжээ. Ийнхүү хот, хөдөөгүй улс орноо хөгжүүлж, сайн сайхан амьдралын төлөө хөлс дуслуулан урам зоригтой хөдөлмөрлөх чин хүсэл эрмэлзлэл бий болсон байна. Чухамдаа ингэж «өөрчлөн байгуулах хүсэл эрмэлзлэлийн төгөлдөржилт» бүрэлдэн тогтжээ. Ард түмний өөрөө өөрийгөө өөд нь татаж улс орныхоо сэргэн мандлын төлөө цуцалтгүй хөдөлмөрлөх чин хүсэл эрмэлзлэлд түшиглэн 1970 оны дөрөвдүгээр сарын сүүлчээр хөдөө нутгийн нүүр царайг өөрчлөн байгуулах их үйлсийн эхлэлийг орон даяар тунхаглаж түүнийгээ «шинэ тосгон хөдөлгөөн» хэмээн нэрлэжээ.

Хөдөө тосгоныг шинэчлэхэд юуны өмнө **сэтгэлээ, гэр бүлээ, хөршөө, тосгоноо** шинэчлэе гэсэн **4 зарчмыг** нэгэн зэрэг дэвшүүлжээ. Тухайлбал, хэнтэй сайн гар нийлж ажиллаж чадахаа сонгосон тэр хүн илүү ихийг хийж чадна гэсэн **сэтгэлийн шинэчлэлээр** эхэлж дараа нь ахуй орчин, гэр орноо сайхан болгож, хөршүүд өөр зуураа байнгын харилцаагаа өргөжүүлж хөршийн холбоо, нигүүлсэн туслалцах сэтгэлтэй болгох, тосгон тосгонтойгоо хорших, нэг үгээр хэлэхэд, өөр хоорондоо уялдаатай шинэчлэлийн үр хөврөл буй болгоход энэ хөдөлгөөн их үүрэг гүйцэтгэжээ. Ардчиллыг бодитойгоор хэрэгжүүлэхэд ч шинэ тосгон хөдөлгөөн ихээхэн түлхэц өгсөн болохыг зохиогч тэмдэглээд хүн бүхэн ардчилалыг шаарддаг боловч ардчилал нь эргээд хүнээс бараг хязгааргүй зүйлийг нэхдэг учиртай болохыг тодорхой өгүүлжээ. (57-р тал)

Хүн хэмээгч сэтгэхүйт амьтан гэдэг нь маргаангүй боловч тэрхүү сэтгэхүй нь **ямагт шунал, хүслийн хүлээснээс үл ангижран манантах тохиол цөөнгүй**. Ард түмэн манан дотор умбаж явахад ардчилал маань хэзээ ч бидэнд дөхөж ирэхгүй. Яагаад гэвэл, **ардчилал сэтгэн бодох, шударгаар хөдөлмөрлөсөн тохиолдолд л нүүр царайгаа харуулдаг**.

Ардчилалыг хэрэгжүүлэх явцад хүмүүст зовлонтой мэт санагдах зүйл байх аваас тэр нь **ардчилалын шаардлага хүний өөрийнх нь шаардлага хоёрын мөргөлдөөн дундаас үүссэн асуудал байх болно**. Ардчилалын шаардлагыг хүлээн авахгүйгээр өөрийнхөө хэрэгцээг урьтал болговоос ардчилал унадаг жамтай болохыг зохиогч онцлон тэмдэглэсэн байна (58-р тал)

Нэг үе Өмнөд Солонгосыг олон улсын банк, НҮБ-ын мэргэжилтнүүд «горьдлогогүй орон», «хөгжихөд бэрхтэй орон» гэх мэтээр дүгнэн бичдэг байсан бол шинэ тосгон хөдөлгөөн өрнүүлж богино хугацааны дотор амжилт олж хөгжин цэцэглэснийг гайхан бичих болжээ. **Шинэ тосгон хөдөлгөөнийг амжилтанд хүргэсэн зүйлс** гэвэл;

1. Тосгоныхоо удирдагчийг өөрсөн дундаасаа сонгосон зарчим.
2. Ард иргэдийн хүчийг бөөгнөрүүлэх зарчим.
3. Хоорондоо зохион байгуулалтын хувьд нарийн холбогдох зарчим.
4. Засгийн газраас дэмжиж туслах зарчим.
5. Тэргүүний тосгоныг эн тэргүүнд хөхүүлэн дэмжих зарчим.
6. «Шинэ тосгон» хүмүүжлийг үргэлжлүүлэх зарчим.
7. Өөр зуураа уялдаат хөдөлгөөнүүдийг зэрэгцүүлэн өрнүүлэх зарчим.
8. Доороос гарах санал бодлыг дээрээ хүлээн авах зарчим эдгээр болно (146—148-р тал)

Шинэ тосгон хөдөлгөөн Өмнөд Солонгосын хөдөө орон нутгийн нийгмийн хамгийн бага нэгж болох энд тэндгүй тархан суурьшсан 34

мянган тосгоныг нийтэд нь хамарсан байна.

Хөдөөгийн нийгэм бүрэлдэхэд нэгэн газар амьдардаг буюу суудаг хүмүүсийн үндсэн сонирхол нэг байна уу үгүй юу гэдэг юу юунаас чухал байдаг аж. Тосгон нь хамтын амьдралын хамгийн бага нэгжийн хувьд хөдөөгийн нийгмийн хамгийн энгийн хэрэгцээ шаардлагыг дэвшүүлэн гаргаж ирдэг байна. Энэ хэрэгцээ шаардлага тосгоныхны эрх ашгаас урган гарсан учир бие биедээ харилцан шүтэлцэн тусалж хамтран ажилласнаар сая хэрэгждэг байна.

Аль ч орны хүмүүст ажил хөдөлмөр хийхэд ялгарах юм байхгүй бүгд ижил. Гагцхүү ямар нэг ажлыг хийх хүсэл сонирхлыг нь хэрхэн бий болгож чадаж байна гэдгээс их зүйл хамаардаг болохыг зохиогч олонтаа тэмдэглээд ажил хийх хүсэл сонирхол бий болгож чадсан явдал шинэ тосгон хөдөлгөөний амжилт олох нэг уг сурвалж болжээ.

Шинэ тосгон хөдөлгөөн өрнүүлснээр довын нэг цацагдсан тосгон болгонд зам тавьж машин явах боломжтой болгож, цахилгаантай болгож, тариалангийн ажлыг механикжуулж эхэлснээр зогсохгүй мацаг барих өлсгөлөнгийн үеийг өнгөрсөн түүх болгож чадсан байна. Хөдөө орон нутгийн нүүр царайг богино хугацаанд шинэчлэн өөрчилсөн энэ хөдөлгөөн орчин үед хөдөө аж ахуйн салбар нь сүйрэлийн ирмэгт байгаа олон оронд гачлан бэрхшээлээс гарах загвар болон олон улсын тавцанд гарч ирсэн байна.

Өнөөгийн Өмнөд Солонгосын хөдөөгийн бүх тосгоны ард иргэд, орон нутгийн байгууллагууд олон улсын харилцаанд орох нөхцөлөө нэгэнт хангаж, худалдаа наймааны эхлэлийн болон төгсгөлийн цэг бааз болж «хөдөө орон нутаг олон улсын шинжтэй» болж буй эрин үетэйгээ зохицон хөгжих замдаа нэгэнт оржээ (119-р тал)

Зохиогч орон нутгийн нийгмийн хөгжил шинэчлэл аливаа улс орон, бүс нутгаас үл шалтгаалан түүний суурь зарчим нь төдийлөн ялгаа байдаггүйг харгалзан шинэ тосгон хөдөлгөөнийг олон улсын шинжтэй болгох боломжийг задлан шинжилж, өөрчлөлт шинэчлэлт хийж байгаа Монгол улсын хөдөөгийн нийгмийн асуудлыг богино хугацаанд шийдвэрлэхэд ямар нэг хэлбэрээр тус дөхөм үзүүлэх чин хүсэл өвөртлөн Өмнөд Солонгос, Монголын хөдөөг харьцуулан судалсан байна. «Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр загварт хот» гэсэн дэд бүлгээ энэ харьцуулсан судалгаандаа зориулжээ. Дэд бүлэг 6 анги, 20 зүйлтэй.

Орон бүрийн бүс нутгууд нийгмийн нөхцөлөөр өөр, ард түмний зан заншил, ахуйн соёл ижилгүй, аж ахуйгаа эрхлэн хөтлөх арга барил хоорондоо ялгаатай боловч шинэ тосгон хөдөлгөөний үзэл санаа өөрийн гэсэн өнгө төрхөө олон, Монголын хөрсөнд амьдрах бүрэн боломжтой гэж зохиогч үзсэн байна.

Зохиогчийн үзэж байгаагаар энэ нь дараах хэдэн шалтгаан нөхцөлөөр тайлбарлагдана.

**Нэгдүгээрт**, дорно дахины ард түмний дотроос монгол хүн, солонгос хүн хоёр бараг ялгахын аргагүй адилхан учраас хэл ам нэвтрэлцэхийн өмнө бие сэтгэлээрээ ойлголцдог.

**Хоёрдугаарт**, монгол, гуулин улсын харилцаанаас үлдэж хоцорсон зүйл одоо хүртэл зан заншил, хэл ярианд нь хэвээр хадгалагдсаар байна. Тиймээс харилцан тохиролцож хялбар зохицож болох талтай.

**Гуравдугаарт**, монголчууд өнө удаан жил таван хошуу малаа шүтэн нүүдлийн амьдралтай явж ирсэн учраас зан ааш чиг шулуун, төв даруу, тусламтгай, байгалийн бэрхшээлийг даван туулах хатуужил сайтай улс.

**Дөрөвдүгээрт**, Монгол оронд өөрчлөлт шинэчлэлт, ардчиллын замаар замнаж зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөөгийн нөхцөлд

ялангуяа нийгмийн хөгжлийг өөд татах талаар өмнөд Солонгосоос суралцах гэсэн монголчуудын үүсгэл санаачлага дээшилсээр байна.

**Тавдугаарт,** Монгол Өмнөд Солонгосоос 16 дахин их нутаг дэвсгэртэй хэдий ч, хүн амаар 20 дахин цөөн,

**Зургаадугаарт,** Монголын хөдөө нутгийнхан бараг бүгдээрээ мал аж ахуй эрхэлдэг, хүн ам цөөн тархай бутархай, соёл ахуйн барилга байгууламжийн хий зай ихтэй. Тэр ч бүү хэл Монголд орон нутгийн нийгмийн тухай ойлголт тун нимгэн бөгөөд орон нутгийн үйлдвэр, эдийн засгийг буй болгож хөгжүүлэх хэрэгцээ ихтэй.

Энэ мэт нь Өмнөд Солонгосын шинэ тосгон хөдөлгөөний нэгэн хувилбар болох гэр загварт хот төслийг монголын нөхцөлд зохистойгоор авч үзэн хэрэгжүүлэх боломжтой гэж зохиогч үзсэн байна (128—130-р тал)

Монгол улс өөрчлөлт шинэчлэлтийн зам дээр гарснаар **өөрийгөө өөрснөө өөрчлөхийг яаравчлахгүй** бол болохгүй. **Өөрчлөлт шинэчлэлт гэдэг нь бусдын зүйлийг авахын тул үүд хаалгаа нээхийн нэр, бусдын нээсэн хаалгаар орохын нэр болно.** Чухам энэ үүднээс номоо бичиж монгол нөхөддөө илгээснээ профессор Кий Юхйөг онцлон тэмдэглэсэн байна (207—208-р тал)

Цаашид хөгжин цэцэглэх ертөнц бол дэлхийн тосгод гэдэг нь маргаангүй бөгөөд тосгодын эрин үед олон улсын шинж чанар гэсэн ухагдахуун дагалдан гарч ирнэ.

Хөдөөгийн нийгэм нь бүхэл бүтэн нийгмийг бүрэлдүүлэх үндсэн нэгж, эд эс болно. Эрүүл эд эсээс эрүүл саруул бие цогцос бүрэлддэгийн нэгэн адил, хөдөөгийн нийгмийг хөгжүүлэх хөдөлгөөн нэн чухал ач холбогдолтой гэдгийг зохиогч цохон тэмдэглэсэн байна (209-р тал)

«Шинэ тосгон хөдөлгөөн ба орон нутгийн өөрөө засахуй» хэмээх гутгаар бүлэг 3 ангитай.

Энэ бүлэгт орон нутгийн байгууллага бүх асуудлыг бие даан хариуцаж, нийгмийн бүх хүчийг тодорхой зорилгод нэгтгэн чиглүүлж, дотооддоо бол орон нутгийн хот байгууламжийн өрсөлдөөнд оролцож, гадаадад бол «орон нутаг олон улсын шинжийг олох» шаардлагад зохицох нөхцөл бүрэлдүүлэхийн төлөө **орон нутгийн «өөрөө засах байгууллага»** ажиллах ёстой. Орчин үеийн нийгэмд бүс нутгийн хөгжил нь физик төлөвлөгөөний шатыг өнгөрч, **хүмүүнлигийн төлөвлөгөөг** голлох болж байна. Ийм нөхцөлд орон нутгийн өөрөө засах байгууллагууд хөдөөгийн хөгжлийг төлөвлөж удирдах үүрэгтэй бол шинэ тосгон хөдөлгөөн нь **хөдөөгийн хөгжилд ард иргэдийг оролцуулах нийгмийн үүргийг гүйцэтгэнэ.** Энэ хоёр ямар ч нөхцөлд нэгдмэл байж, орон нутгийн шинэ эрин үеийг нээх болно.

Орон нутаг өрсөлдөөний үед нэгэнт шилжсэн тул орон нутгийн нөөц хүчийг нэгтгэж эс чадваас бүс нутгийн сульдалтыг тойрч гарахад бэрхтэй. Орон нутаг олон улсын шинжийг олж буй өнөө үед бие даан гадаадтай өрсөлдөх бааз сууриа бэхжүүлж, олон улсын мэдээллийн номхон төв болох бэлтгэл хийх хэрэгтэй гэж зохиогч цохон тэмдэглэжээ (227-р тал)

Энэ номд монголын хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодууштай олон чухал санаа байна. Гэхдээ гэрийн ахуйг өөрчлөх зэрэг асуудал манай орны хувьд ойрын ирээдүйн зорилт биш болох нь мэдээж.

Нэг үе сум орон нутгийг социалист суурин болгож хувиргах уриан дор малчид цөөрч, хүн ам зохиомлоор хэт төвлөрч, малчдын нэлээд хэсэг нь машин хүрэх газар бараадан эргэлдэх болсноор бэлчээр нут-

гийн үлэмжхэн хэсэг эзгүйрч, уламжлалт унаа хөсгөө хэрэглэх нь ховордож, хот суурингийн орчны нутаг хүн малын хөлд талхилагдсан билээ. Зарим газар асар их зардал гаргаж байшин барилга барьж малчдыг суурьшуулах гэж үзсэн. Сүр дуулиан ихтэй ийм үзүүлэх сургууль «амжилттай» болсны маргаашаас эзгүйрч хоцордог байсныг энд нурших нь илүүц бизээ. Энэ бүхэн юу харуулж байна вэ? гэвэл монгол орны өвөрмөц байдал, нүүдлийн соёл иргэншилд аливаа загвар амьдрах чадваргүй болохыг харууллаа.

Ер нь бид өөрсдийн гэсэн замаар явахдаа их хойрго, сав л хийвэл аль нэг орон, газрыг дууриаж хуулбарлах гээд байдаг улс. Дээр нь нэмээд бусдын тусламжаар амархан хөгжиж болох юм шиг сэтгэдэг болсон. Сүүлийн үед энэ өвчин бүр ч газар авчээ. Гэтэл солонгосчууд биднээс дор амьдарч байхдаа бусдын гар харсангүй. Шаварт унасан шарын эзэн хүчтэй гэгчээр төрөлх тосгоноо өөрсдийн хүчээр өөрчлөн шинэчилж, хүн бүр өөрийгөө өөд нь татаж амьдрах ухааныг олсноор богино хугацаанд хөдөө нутгаа, өөрсдийгөө дэлхий дахинд гайхуулах болтол нь хөгжүүлж чадсан байна. Өөрийн хүчинд тулгуурлан хөгжихийн бодит жишээ энэ буюу.

Монголчууд бид өөрийн гэсэн замаар явж, өөрсдийнхөө хувь заяаг өөрсдөө шийдвэрлэх ёстой гэдэг хатуу үнэнийг эрдэмтэн Ким Юхёгийн энэ бүтээл сануулж байна.

БНСУ-ын эрдэмтэн Ким Юхёгийн «Шинэ тосгон хөдөлгөөн ба гэр загварт хот» номын шүүмжийг үүгээр хязгаарлаж, өгүүлэхэд энэхүү ном монголын хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэхүйц дорвитой сайн бүтээл мөн болохыг тэмдэглэмээр байна.

Олон уншигчид, Монголын хөдөөгийн нийгмийн хөгжлийн төлөө санаа тавьж бие сэтгэлээ зориулж яваа малчид, тариаланчид, хөдөө орон нутгийн удирдах ажилтан нар, судлаачдад зориулан энэ номын монголын хөдөөгийн нийгмийн хөгжлийн асуудлаар хийсэн судалгааны зарим хэсгийг товчлон манай эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлэх нь зүйтэй шиг санагдана.

Эцэст нь тэмдэглэхэд 1991 оны гуравдугаар сард манай улсын гол гол яам, тусгай газрын эдийн засгийн асуудал хариуцсан тэргүүн шарлар сайд, газрын дарга нар, 18 аймгийн тэргүүн дэд дарга зэрэг бүгд 31 хүн БНСУ-д мэргэжил дээшлүүлэх дамжаанд суралцсан байна. Тэдэнд эрдэмтэн Ким Юхёг хөдөөгийн нийгмийн хөгжлийн асуудлаар лекц уншиж өөрийн санаа бодлоо хуваалцжээ. Тэд ч энэ асуудлыг ихээхэн сонирхож Өмнөд Солонгосын хөдөө нутгаар явж, шинэ тосгон хөдөлгөөн хэрхэн биелэлээ олсныг газар дээр нь үзэж танилцсан байна.

Профессор Ким Юхёгийн монголын хөдөөгийн нийгмийн хөгжлийн асуудлаар хийсэн судалгаа чухамдаа дээрх нэр бүхий хүмүүсийн хүчин зүтгэл оролцоотойгоор хэрэгжихийн учир тэр буй заа.

Түүнчлэн 1991 оны эхээр манай улсын судалгааны байгууллагуудын хамтран хийлгэсэн «Гэр загварт хот» хэмээх эрдэм шинжилгээний бага хуралд зохиогчийн энэ сэдвээр тавьсан илтгэл судлаачдын сонирхлыг ихээхэн татаж байсныг энэ дашрамд тэмдэглэхэд таатай байна.